

БАЙГАЛИЙН ЗАГАС

УРЖҮҮЛЭГЧИД

НҮТББ

НИЙТ 3.8 САЯ+

ЖАРАМГАЙГ

ЧУЛУУТ БОЛОН ИЛЭНХ ГОЛУУДАД ТАВЬСАН 2019–2026

ХАМГААЛАЛ ЭН ТЭРГҮҮНД

Байгалийн Загас Үржүүлэгчид

Байгалийн Загас Үржүүлэгчид НҮТББ нь цэнгэг усны экосистем, загасны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажилладаг ашгийн бус байгууллага юм.

Бид “Чулуут тул” болон “Илэнх” төслөөр дамжуулан доройтсон загасны нөөцийг нэмэгдүүлэх, гол мөрний экологийн тэнцвэрийг хадгалах, загасыг байгалийн жамаар өсөж үржих таатай нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.



Үүний зэрэгцээ бид голын эрэг орчмын бүсийн хамгаалалт, нөхөн сэргээлт, мод сөөг тарих, ургамалжилт болон байгалийн ногоон орчныг хамгаалах чиглэлээр цаашид ажиллахыг зорьж байна. Мөн ус, байгаль орчныг хамгаалах мэдлэг, зөв хандлагыг олон нийтэд түгээж, энэ чиглэлээр суралцах сонирхолтой хүүхэд, залуусын боловсрол, танин мэдэхүй, хээрийн дадлага, цаашдын хөгжлийг дэмжинэ.



Тул загас нь идэш тэжээлийн хэлхээний дээд түвшний махчин учраас түүний гол идэш болох зэвэг, хадрангийн тогтвортой нөөц шаардлагатай. Тиймээс бид тулын экологийн хэрэгцээнд нийцүүлэн зэвэг, хадранг үржүүлж, байгалийн сүргийг нэмэгдүүлэх ажил хэрэгжүүлж байна.

Манай үйл ажиллагаа зөвхөн ховордсон загасыг хамгаалахаар хязгаарлагдахгүй. Бид идэш тэжээлийн хэлхээ, амьдрах орчин, биологийн олон янз байдлын уялдаанд тулгуурлан гол мөрний экосистемийг бүхэлд нь сэргээхийг зорьдог.

БИДНИЙ ОРШИХУЙН ҮНДЭС

Цаг уурын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа, бэлчээрийн доройтол, бохирдлын нөлөөгөөр гол мөрний экосистем болон уугуул загасны амьдрах орчин доройтож байна. Үүний улмаас зарим зүйлийн нөөц буурч, устах эрсдэл нэмэгдэж байна.

Иймээс бид уугуул загасны нөөцийг хамгаалах, үржүүлэх, сэргээн нутагшуулахын зэрэгцээ тэдгээрийн амьдрах орчныг цогцоор нь хамгаалахад чиглэн ажиллаж байна. Энэ нь гол мөрний эрэг орчмын бүсийг нөхөн сэргээх, усны чанар болон биологийн олон янз байдлыг хянах, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагааг хамарна.



Бидний зорилго нь зөвхөн загасны нөөцийг нэмэгдүүлэх бус, гол мөрөн, цэнгэг усны экосистемийг урт хугацаанд тогтвортой хамгаалж, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх явдал юм.

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО,

Бидний алсын хараа

Байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн, байгалийн нөөц жам ёсоор сэргэх усан орчны экосистемийг бүрдүүлсэн, иргэн бүрийн оролцоо болон зөв хандлагыг харуулсан ирээдүйг цогцлооно.

Эрхэм зорилго

Ховор болон агнуурын төрөл зүйл загасыг зориудын үржүүлэгт тулгуурлан байгалийн нөөцийг сэргээх, цэнгэг усны экосистемийг хамгаалан, байгаль орчны тогтвортой байдлыг бий болгоход оршино.



ҮНЭТ ЗҮЙЛС

Хамгаалал ба Хариуцлага

Цаг уурын өөрчлөлт, байгаль орчны доройтлын эсрэг төслөөрөө дамжуулан гол мөрөн, уугуул загасыг сэргээж, устах эрсдэлээс хамгаалан, байгаль орчны тогтвортой ирээдүйн төлөө хариуцлагатай ажиллах нь бидний үнэт зүйл юм.

Манлайлал ба Уриалга

Байгаль орчныг хамгаалах үйлсэд сайн дурын санаачилгаар нэгдэж, иргэдийн оролцоог манлайлан, олон нийтийг тогтвортой хөгжлийн төлөө хамтдаа эх дэлхийгээ хайрлан хамгаалахыг уриалах нь бидний үнэт зүйл юм.



Ирээдүй ба Үр дүн

Өнөөдөр бидэнд үлдэж буй байгалийн нөөцийг ирээдүй хойч үедээ өвлүүлэхийн төлөө зорьж, эх дэлхий, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих үйл ажиллагааг түгээж, бодит үр дүнг чухалчилж, хамтдаа ногоон ирээдүйг бүтээж байгаа нь бидний үнэт зүйл юм.

Мониторинг ба Судалгаа

Мэргэжлийн биологич, судлаачдын хамт олон улирал бүр мониторинг, судалгаа, ажиглалт хийж, салбарын мэргэжилтнүүдтэй хамтран өнөөгийн нөхцөл байдал, ажлын үр дүнг бодитоор үнэлэх нь бидний үнэт зүйл юм.

ЧУЛУУТ ТУЛ ТӨСӨЛ



“Чулуут тул” төсөл нь “Байгалийн загас үржүүлэгчид” НҮТББ-аас 2019 онд **Архангай аймгийн Тариат** сумын Алтаад багийн нутаг дахь Чулуут голын сав газарт хэрэгжүүлж буй байгаль хамгааллын төсөл юм.

Төсөл нь нэн ховор **тул загас** (Hucho taimen)-ны байгалийн популяци болон амьдрах орчныг хамгаалахад чиглэдэг. Үүний хүрээнд тулын гол идэш болох **зэвэг, хадран** загасыг үржүүлж, Чулуут голын сав газарт сэргээн нутагшуулан, идэш тэжээлийн суурь нөөцийг бэхжүүлж байна.

Мөн загасны нөөцийн судалгаа, улирлын мониторинг, голын амьдрах орчны ажиглалт, нутгийн иргэдийн хамтын оролцоонд суурилсан хамгааллын ажлуудыг тогтмол хэрэгжүүлдэг.



Сүүлийн найман жилийн хугацаанд өнөөдрийн бидний хэрэгжүүлж буй ажлыг бүтээн байгуулах замд олон сорилт бэрхшээлтэй тулгарч, мөн олон амжилтыг хамтдаа тууллаа. Эргээд харахад энэ бүх замнал, биднийг үргэлж дэмжиж ирсэн олон сайхан хүмүүстээ гүн талархаж явдгаа илэрхийлье.

Энэ хугацаанд бид үнэтэй туршлага хуримтлуулж, олон сэтгэлтэй, тууштай хувь хүн болон байгууллагатай хамтран ажиллах завшаан тохиосон. Бидний өнөөдрийн амжилтад нутгийн иргэдийн итгэл, идэвхтэй оролцоо, тууштай дэмжлэг онцгой хувь нэмэр оруулсан билээ.

Цаашид бид цэнгэг усны экосистемийг хамгаалах, байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх, ирээдүй хойч үедээ илүү эрүүл, тогтвортой байгаль орчныг үлдээхийн төлөө улам хичээнгүйлэн ажиллах болно.

Илэнх төсөл

“Илэнх” төсөл нь “Чулуут тул” төслийн сайн туршлагад тулгуурлан 2026 оны 4 дүгээр сард Булган аймгийн Тэшиг сумын Далан багийн нутаг, Илэнх–Эрин голын бэлчирт хээрийн лаборатори байгууллаа.



Лаборатори нь үржлийн улиралд **750,000** хүртэлх жарамгай бойжуулах хүчин чадалтай. Үржүүлэг, өсгөвөрлөлтийн ажлыг тогтвортой явуулахын тулд түрс бойжуулах 7 инкубатор, жараахай өсгөвөрлөх 6 танк, мөн биологич, судлаачдын ажиллах оффис, судалгаа-шинжилгээний орчныг бүрдүүлсэн.

“Илэнх” төслийн нээлтийн арга хэмжээнд хүрэлцэн ирж, төслийн үйл хэрэгт итгэл хүлээлгэн дэмжсэн хүн бүрд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхний итгэл хүлээлгэж буй нь төслийн үр өгөөжтэй, тогтвортой хэрэгжилтийн чухал үндэс юм.



Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагуудтай бат бөх, урт хугацааны түншлэл бий болгоход бид онцгой анхаарч ажиллана. Мөн Булган аймагт шинээр хэрэгжиж эхэлсэн “Илэнх” төслийг сонирхож, хамтран ажиллах, хувь нэмрээ оруулах хүсэлтэй иргэн, байгууллага, судлаач, түнш бүхнийг бид халуун дотноор урьж байна.

Бид төслийн хүрээнд нийт 4 сая гаруй
жарамгайг голд амжилттайгаар тавьсан байна.



4 сая гаруй жарамгайг голд амжилттайгаар тавьсан байна.




Нийт мэнд үлдэлт нь **90%** тай байна



төслийн хүрээнд **4 сая 200 мянга** гаруй түрс шахаж авсан байна

Анх төсөл хэрэгжүүлснээс хойш голд буцаан тавьсан
ЖАРАМГАЙН ТОО





ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ДӨРВӨН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БА ДЭД ЧИГЛЭЛҮҮД

Манай төрийн бус байгууллага сүүлийн найман жилийн хугацаанд Монгол орны уугуул загасны нөөцийг хамгаалах, үржүүлэх, сэргээн нутагшуулах чиглэлээр тогтвортой ажиллаж, бодит туршлага хуримтлууллаа.

Цаашид бид загасны үржүүлэг, сэргээн нутагшуулалтаас гадна усны экосистемийн хамгаалал, нөхөн сэргээлт, биологийн олон янз байдлыг хадгалах, судалгаа, мониторинг, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.

ҮНДСЭН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

1. Загас үржүүлэг

Уугуул загасыг үржүүлж, байгальд сэргээн нутагшуулахын зэрэгцээ PIT мониторингоор амьд үлдэлт, шилжилт хөдөлгөөнийг хянах мөн генетикийн судалгаа гэх мэт ажиллагааг идэвхтэй хийж эхлэх.

2. Хамгаалал нэн тэргүүнд

Орон нутгийн идэвхтэн, байгаль хамгаалагчдыг бэлтгэж, эргүүл, хамгаалалт, байгаль орчны боловсролын ажлыг өргөжүүлнэ.

3. Мод үржүүлэг

Мод үржүүлгийн газар байгуулж, голын эрэг орчим болон олон нийтийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод сөөг тарих, ургамалжилтыг хамгаалах ажлыг хэрэгжүүлнэ.

4. Ирээдүйн судлаачид

Залуу үеийг сургалт, тэтгэлэг, дадлагын хөтөлбөрөөр дамжуулан байгаль хамгаалал, судалгааны салбарын мэргэжилтэн болгон бэлтгэнэ.


ДЭД ЧИГЛЭЛҮҮД

1. Нийгмийн халамж
Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асаргаа шаардлагатай хүүхдүүдэд дэмжлэг үзүүлж, ээлтэй орчин бүрдүүлнэ.

2. Соёл, өв, боловсрол
Музей, номын сан, соёлын өв, баримтат кино зэрэг боловсролын агуулгыг хөгжүүлнэ.

3. Ногоон байгууламж, орчин
Сургууль, зам талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

4. Онцгой байдал ба аврах ажиллагаа
Гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах болон сэргээн босголтын ажилд дэмжлэг үзүүлнэ.



ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨВЛӨГӨӨ:

ИРЭЭДҮЙН СУДЛААЧДЫГ БОЛОН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ БЭЛТГЭХ

Цэнгэг усны хамгааллын хүний нөөцийн тогтолцоо

Монголын цэнгэг усны экосистемийг хамгаалахад загас судлал, усны экологи, сэргээн нутагшуулалтын чиглэлийн мэргэшсэн хүний нөөц шаардлагатай байна. Гэвч орон нутгийн залууст мэдлэг, хээрийн дадлага, санхүүгийн дэмжлэг болон мэргэжлийн ажлын боломж хязгаарлагдмал байдаг.

Иймээс бид сурагч, оюутны сонирхлыг хөгжүүлэхээс эхлээд хээрийн сургалт, тэтгэлэг, судалгааны дадлага, ажлын байраар үргэлжлэх хөгжлийн замыг бүрдүүлэхээр зорьж байна.





1. Ойлголт ба мэдлэг

Сурагчдад цэнгэг усны экосистем, уугуул загас, гол мөрний хамгааллын ач холбогдлыг таниулж, сургалт, тэмцээн, хээрийн дадлагаар дамжуулан байгаль хамгаалалд оролцох боломж олгоно.

2. Хээрийн сургалт

Сонгогдсон хүүхэд залуус Чулуут, Илэнх зэрэг хээрийн станцад загас үржүүлэг, мониторинг, усны экологи, амьдрах орчны хамгааллын бодит ажилтай танилцаж, мэргэжлийн судлаачдын удирдлага дор дадлага хийнэ.



3. Судалгаа ба тэтгэлэг

Загас судлал, усны экологи, биологи болон байгаль орчны чиглэлээр суралцаж буй оюутнуудад тэтгэлэг, судалгааны грант, дипломын ажлын санхүүжилт, дадлагын боломж олгоно.

4. Мэргэжлийн дараагийн үе

Хөтөлбөрийн оролцогчид судлаач, хээрийн мэргэжилтэн, сургагч багш болон хөгжиж, Монголын цэнгэг усны хамгааллын ирээдүйн чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна.

Энэхүү тогтолцоо нь зөвхөн тэтгэлэг, сургалтын хөтөлбөр биш бөгөөд мэдлэгээс дадлага руу, дадлагаас мэргэжил рүү, мэргэжлээс дараагийн үеийг бэлтгэх хүртэл үргэлжлэх байгаль хамгааллын тогтвортой мөчлөг юм.

ИРЭЭДҮЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
PIT МОНИТОРИНГ





Байгалийн Загас Үржүүлэгчид нь Монголын гол мөрний уугуул загасны амьдралын мөчлөгийг судалж, байгаль хамгааллын ажлын бодит үр дүнг үнэлэх зорилгоор PIT чип суулгалтын технологийг цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

PIT чип нь будааны ширхэгтэй ойролцоо хэмжээтэй, давтагдашгүй дугаар агуулсан маш жижиг микрочип юм. Зай шаарддаггүй бөгөөд загасны хэвийн хөдөлгөөнд саад болохгүй. Мэргэшсэн баг чипийг загасанд болгоомжтой суулгах бөгөөд тухайн загас хяналтын антеннын дэргэдүүр өнгөрөх, эсвэл гар уншигчаар шалгагдах үед дахин таних боломжтой болно

Энэхүү технологийг ашигласнаар тавьж нутагшуулсан загасны амьд үлдэлт, шилжилт хөдөлгөөн, амьдарч буй болон үржих чухал бүсүүдийг урт хугацаанд судалж, сэргээн хамгаалсан голын хэсгүүд загасны популяцид ямар үр нөлөө үзүүлж байгааг үнэлэх боломж бүрдэнэ. Цугларсан мэдээлэл нь манай баг хамт олонд цаашдын үржүүлэг, нутагшуулах ажлаа сайжруулах, үржлийн чухал бүс нутгийг хамгаалах, мөн тул, зэвэг, хадран зэрэг уугуул загасны зүйлүүдийг хамгаалахад шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг болно.



Байгалийн Загас Үржүүлэгчид

Т Б Б



ХАМТРАГЧ БОЛОН ИВЭЭН ТЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

ПЕТРОВИС

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБА

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

SHOAL CONSERVATION PARTNER

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

ӨНДӨР-УЛААН

ЭРДЭМ

ЖАРГАЛАНТ СУМ

ХААИС MONGOLIAN UNIVERSITY OF LIFE SCIENCES

TOP MOTORS

Бидний ажлыг дэмжиж хамтран ажилладаг түнш байгууллагууд, ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч нартаа талархлаа илэрхийлье.

БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ

Бидний хэрэгжүүлж буй загас үржүүлгийн хөтөлбөрүүд, амьдрах орчныг сэргээх үйл ажиллагаа, мөн шинжлэх ухаанд суурилсан судалгаанууд нь Монголын гол мөрнийг ирээдүй хойч үедээ амьд, баялаг хэвээр нь үлдээхэд чиглэдэг. Таны дэмжлэг болон бидний ажлын хөлс хөдөлмөр эдгээр гол мөрний ирээдүйг хамгаалах гол хүчний нэг юм.

вэбсайт ба
сошиал сувгууд

Хандив — **QPay**

Хаяг:
501 тоот, 5-р давхар, Шинэ Мянганы Барилга
8-р хороо, Хан-уул дүүрэг, Улаанбаатар
Имэйл хаяг:
info@naturalfishbreeders.org
info@chuluuttul.org
Холбогдох дугаар
+976 89891809

naturalfishbreeders.org
ilenkh.org
chuluuttul.org